



Хэн Анхаарна гэж?

ИВЭЭЛ Их Эзэн биднийг мэддэг бөгөөд бидэнд санаа тавьдаг.

Унших Зүйл

Эхлэл 37:12-28; Эцэг Өвгөд ба Зөнчид, х. 208-212.

Цээжлэх Ишлэл

"Айх үедээ би танд итгэлээ өгнө" (Дуулал 56:3).

Зорилго

Хүүхдүүд дараах зүйлст суралцана:

Тэднийг хаана ч байсан Их Эзэн тэдний залбирлыг сонсож тэдэнд санаа тавих болно гэдгийг **мэдэх** болно.

Их Эзэн тэдэнтэй үргэлж хамт байдаг гэдэгт **итгэлтэй байх** болно.

Их Эзэний явуулахыг хүссэн газарт явахаасаа **айхгүй байх** болно.

Гол Санаа



Бид айсан үедээ Их Эзэнд л найдах хэрэгтэй.

Хичээлд Бэлтгэх нь

Библийн Хичээлийн Товчлол

Иосеф аавынхаа хамгийн хайртай хүү нь байсан болохоор ах нар нь түүнд их атаархдаг. Ах нарыг нь хол газар хонь хариулахаар явахад аав нь Иосефыг ах нарыгаа сайн байгаа эсэхийг нь мэдээд ир хэмээн явуулжээ. Иосеф ах нар дээрээ очиход ах нар нь түүнийг хороохоор шийдсэн боловч тэд Иосефыг Египет рүү явж байсан нэгэн худалдаачинд боол болгон зарчихжээ. Иосеф аавынхаа ярьж өгсөн Их Эзэний тухай бүх түүхийг санаж байсан бөгөөд хэдий айж байсан ч Их Эзэнд бүхий л амьдралдаа бүрэн итгэдэг байлаа.

Энэ бол ивээлийн тухай хичээл

Их Эзэн бид бүгдийг харж байдаг бөгөөд бидний баяр хөөр, ирээдүй, сорилтыг мэдэж байдаг юм. Бидний өгөөмөр Их Эзэн бидэнд тохиолдож буй бүх зүйлд санаа тавьж байдаг бөгөөд Тэр биднийг айх үедээ ч Өөрт нь итгээсэй хэмээн хүсэж байдаг.

Багшийн Баяжуулалт

"Уй гашуу, аймшигаар дүүрэн байхдаа Иосеф ирээдүйгээ айсан сэтгэлээр харж байлаа.

"Гэвч Их Эзэний тааллаар энэ туршлага нь ч түүний хувьд ивээл байсан юм. Тэр хэдхэн цагийн дотор л аль үед эдгээрийг сурснаа мэдэх болно.

АРАВ

Хичээлийн Төлөвлөгөө				
ХИЧЭЭЛИЙН ХЭСЭГ	ХУГАЦАА	ҮЙЛ АЖИЛЛАГАА	ХЭРЭГЦЭЭТЭЙ МАТЕРИАЛ	
Мэндчилгээ	үргэлжлэх	Хүүхдүүдээ угтах, тэдний сэтгэгдлийн талаар асуух		
1	Бэлтгэх Ажил	10 минут	<i>А. Олсон Дээгүүр Явагч</i> <i>Б. Итгэлийн Амт</i>	урт олс эсвэл наалддаг тууз янз бүрийн дайллага
*	Залбирал ба Магтаал*	10 минут	103-р хуудсыг үз. *Залбирал ба Магтаал -ыг хөтөлбөрийн дундуур аль ч үед хийж болно.	
2	Библийн Хичээл	20 минут	Түүхтэй Танилцах	жүжигчин хүүхэд, эрээн өнгийн хүрэм, нөмрөг эсвэл цамц, сүрчиг, 20 ширхэг мөнгөн зоос
			Библи Судлал	Библи
			Цээжлэх Ишлэл	Библи
3	Хичээлээ Заах	15 минут	<i>А. Итгэлийн Алхам</i> <i>Б. Айдсын Шидэлт</i>	нүд боох алчуур бөмбөг
4	Хичээлээ Хуваалцах нь	15 минут	<i>Бурханы Гарт</i>	Бурханы гарны загвар (146-р хуудас), цаас, өнгийн харандаа, <i>Бяцхан хүүхдүүд Түүнийг магтана</i> дууны ном

Аав нь илүү их хайрлах сэтгэлээсээ болоод ялган үзэх алдаа хийсэн.

... Алдаагаа ухаарвал одоо ч засаж болно. Тэр зөвхөн өөрөө өөрийгөө л боддог

"Тэгээд түүний бодол аавынх нь Их Эзэн рүү эргэжээ. Тэр багадаа хайрлахыг бас Их Эзэнээс эмээхийг заалгасан. Заримдаа тэр аавынхаа майхны тэндээс түүнийг хэрхэн оргон гарсан тухай түүх сонсдог байв. Их Эзэн Иаковт амласан амлалтаа хэрхэн биелүүлсэн, хэрэгтэй үед Их Эзэний элч нар түүнд зөвлөхөөр хэрхэн ирж байсан,

түүнийг хэрхэн хамгаалж байсан тухай олон зүйлийг Иосеф сонсож байжээ...

Аавынх нь Бурхан өөрийнх нь ч Бурхан байна гэдэгт Иосеф итгэдэг. Тэгээд тэр Их Эзэнд өөрийгөө бүрэн өгч хэцүү үед хамт байхыг Их Эзэнээс гуйжээ". (Эцэг Өвгөд ба Зөнчид, х. 213, 214).

Та хэзээ хамгийн их айж байсан бэ? Тэр үед та Их Эзэнд хэр зэрэг ойр байв?

Өрөөний Зохион Байгуулалт

Нэгдүгээр хичээлд хэрэглэсэн тайзны заслыг ашигла. 3, 7, 8-р хичээлд ашигласан нүх хийх хар даавууг хэрэглэ.

Заах Хичээл

Мэндчилгээ

Сурагчдаа угтан авч амралтаа хэрхэн өнгөрүүлсэн, юу сайхан байсан, юу хэцүү байсан талаар асуугаад, өнгөрсөн долоо хоногийн хичээлээс сурсан зүйлээ бусадтай хуваалцахад нь урам өгөөд өөртөө тохиромжтой байдлаар хичээлээ эхлүүлээрэй.



Бэлтгэх Ажил

Анги болон нөхцөл байдалдаа хамгийн тохиромжтой хувилбарыг сонгоорой.

А. Олсон Дээгүүр Явагч

Хэрэгтэй зүйлс:

- урт олс эсвэл наалддаг тууз

Урт уяагаа шалан дээгүүр нэг чигт тавиад хүүхдүүдийг нэг эгнээ болгон зогсоогоорой. Хэлэх: **Олс гэж та нар мэдэх үү? Та нар телевизороор эсвэл циркэд өндөрт татсан олсон дээр хүн явж байхыг харсан байх. Тэр бол олсон дээгүүр явдаг хүн юм. Одоо та нар олсон дээгүүр явдаг хүн болж харин би та нарыг энэ олсон дээгүүр хэр болгоомжой явахыг чинь харах болно. Энэ олсыг их өндөрт байгаа гэж бод. Чи унахыг хүсэхгүй байгаа. Хэрвээ унавал, олсны төгсгөлд очоод дахин оролдоод үзээрэй.**

Бататгах нь

Хүүхдүүдэд хариулах боломж гаргаарай: **Олсон дээр хөлнийхөө тэнцвэрийг олоход амархан байна уу? Хэцүү байна уу? Та нар өөрийгөө их өндөрт байна гэж төлөөлсөн үү? Энэ аймаар байсан уу? Бодит амьдрал дээр олсон дээгүүр явах нь аймаар уу? Бодит амьдрал дээр та нар юунаас илүү их айдаг вэ?**

Өнөөдрийн үзэх Библийн түүх маань ах нарыгаа өөрт нь атаархаж хорлохыг санаархаж байгаад ямар их айж байсан Иосеф хүүгийн тухай үзэх болно. Хэдийгээр тэр айж байсан ч Их Эзэнд итгэхээр шийджээ. Өнөөдрийн хичээлийн гол утга санаа бол:



Бид айсан үедээ Их Эзэнд л найдах хэрэгтэй.

Намайг дагаад хэлээрэй.

Б. Итгэлийн Амт

Хэрэгтэй зүйлс:

- янз бүрийн амттан

Үүнийг хийхийнхээ өмнө хүүхдүүдээс ямар нэгэн хүнсний зүйлд харшилтай эсэхийг асуугаарай. Үзэм, самар, печень зэргийг бэлдээрэй. Хэлэх: **Нүдээ аниад бүгдийг амсаж дуустал аниастай байлгаарай. Би хүүхэд нэг бүр дээр очоод аманд нь амттай зүйл хийж өгөх болно.**

Бататгах нь

Хүүхдүүдэд хариулах боломж гаргаарай: **Намайг аманд чинь ямар нэгэн зүйл хийхэд та нар юу бодож байсан бэ? Намайг та нарыг хуурч аманд чинь муухай амттай зүйл хийж өгөх бол уу хэмээн айж байсан**

уу? Та нар надад итгэж байсан уу? Яагаад? Та нар өөрсдийгөө Их Эзэнд итгэж болно гэдгээ мэдэх үү? Тэр чамайг хэзээ ч хуурахгүй.

Өнөөдрийн бидний үзэх Библийн түүх бол өөрт атаархаж хорлохоор шийдсэн ах нараасаа Иосеф хэрхэн айж байсан тухай юм. Тэр хэдийгээр айж байсан ч Их Эзэнд итгэхээр шийджээ. Өнөөдрийн гол утга санаа:



Бид айсан үедээ Их Эзэнд л найдах хэрэгтэй.

Намайг дагаад хэлээрэй.

ЗАЛБИРАЛ БА МАГТААЛ



Нөхөрлөл

Хүүхдүүдээ угтахдаа долоо хоног яаж өнгөрсөн бэ гэж асуугаад хүүхдүүдийн хариулсан сайн муу (таалагдсан, таалагдаагүй зүйлийнх нь тухай) хариултыг (зохистой гэж үзвэл) бусадтай нь хуваалцаарай. Анх ирсэн сурагчдыг ялангуяа талархан угтаж, тэднийг танилцуул. Төрсөн өдөр зэрэг онцгой үйл явдлыг тэмдэглэж байгаарай.

Санал Болгох Дуунууд

"Тийм ээ, Есүс надад санаа тавьдаг" (*Бяцхан хүүхдүүд Түүнийг магтана, №. 118*)

"Түүний гарт бүхий л ертөнц бий" (*Бяцхан хүүхдүүд Түүнийг магтана, №. 125*)

"Их Эзэн намайг халамжилдаг" (*Бяцхан хүүхдүүд Түүнийг магтана, №. 90*)

"Би маш жижигхэн" (*Бяцхан хүүхдүүд Түүнийг магтана, №. 96*)

Зорилго

Хүүхдийн Үйлчлэл сэтгүүлээс нэгэн түүх уншиж өгөөрэй. Асуух:

Өнөөдрийн түүхэнд Их Эзэн хүмүүст хайртайгаа хэрхэн харуулж вэ?

Хандив

Хэлэх: **Их Эзэн бидэнд үргэлж санаа тавьж байдаг. Бид өргөлөө авчирч Түүнд баярлалаа гэж хэлцгээе.**

Залбирал

Асуух асуултандаа хариулах хугацаа олгоорой: **Чи юунаас айдаг вэ?** Хэлсэн зүйлийг нь тогтоож авах эсвэл бичиж авахад тань туслах туслагч хэрэгтэй. **Бурхан чамд тусална гэдэгт итгэж байна уу? Чи айсан үедээ ч гэсэн Их Эзэн чиний төлөө сайныг хийнэ гэдэгт итгэх үү? Бүгдээрээ үүний төлөө залбирцгаая.** Хүүхэд бүрийн айдсын төлөө залбирахдаа хүүхдүүдийг нэрээр нь дуудаарай.

* Залбирал ба Магтаал-ын цагийг хичээлийн аль ч үед явуулж болно.

2

Библийн Хичээл

Түүхтэй Танилцах

Хэрэгтэй зүйлс:

- жүжигчин хүүхэд
- эрэн өнгийн нөмрөг
- хүрэм эсвэл цамц
- бор даавуу
- сүрчиг
- 20 ширхэг мөнгөн зоос

Иосефын дүрд тоглох хүүхдийг сонгоод эрэн өнгийн хувцас өмсүүл. Бор өнгийн том даавууг ашиглан нүх шиг харагдуулах ба тэр нүх рүү Иосефын ах нар түүнийг хийнэ.

Түүхийг уншиж эсвэл ярьж болно.

Иосеф гэрийнхээ доороосоо хоёр дахь нь байв. Түүнд арван ах нэг дүү бас олон эгч нар байжээ. Тэдний гэр бүл Канаанд амьдардаг. Тэд майханд амьдарч олон толгой малтай байв.

Хонь маш их өвс иддэг. Иосефын амьдарч байсан газар хүмүүс нүүдэллэн явж сайн өвстэй газар хонио бэлчээрлүүлдэг байв. Иосефын

ах нар хоньдоо аваад илүү сайн үржил шимтэй газар олохоор явав. Иосефын аав тэднийг сайн байгаа эсэхийг мэдэхийг хүсчээ. Тэдэнд хоорондоо холбоо утас байхгүй. Тэд хоорондоо захиа бичиж ч чадахгүй. Тэгээд Иаков тэдний хойноос Иосефыг явуулав.

Иосеф цүнхээ бэлдээд ах нараа олохоор гэрээсээ явлаа. *[Иосефыг өрөөгөөр явуулан буцааж суудалд нь суулга.]* Тэднийг олоход нэлээн удсан боловч эцэст нэг юм барааг нь харжээ. *[Гараараа нүдээ саравчлан холыг харах хүүхдүүд таныг дуурайн хийх болно.]*

Иосеф ах нараа хараад ихэд баярлан тэднийг ч мөн өөрийг хараад баярлах байх гэж бодлоо. Гэхдээ та нар юу гэж бодож байна? Үгүй ээ. Тэд Иосефын зүүдний болон аавынх бэлэглэсэн гоё хувцасны тухай ярьж байв. Тэд одоо хүртэл атаархаж уурласаар байлаа.

Иосефыг өөдөөс нь ирж явааг хараад ах нар нь түүнийг яаж хорлож ямар муу зүйл хийхээ ярилцав. Иосефыг тэдэн дээр очиход тэд нар гоё хувцсыг нь тайлж аваад харанхуй нүхэнд шиднэ. *[Иосефын хувцсыг*

тайл, тэгээд түүнийг бор нүхэнд суулга.]

Реубен бол Иосефын том ах нарын нэг, тэрээр Иосефыг нүхнээс гаргах санал гаргажээ. Тэр Иосефыг гэмтээхийг хүсэхгүй байв. Бусад ах нар нь Иосефын авчирсан хоолыг идээд дүүгээ яахаа ярилцан сууна.

Реубенийг жаахан холдмогц нөгөө ах нар нь уртаас урт жингийн цуваатай хүмүүс ирж явааг харна. Тэмээн дээр халуун ногоо үнэртэн ачсан байв. *[Хүүхдүүдэд халуун ногоо болон үнэртэй ус үнэрлүүл.]* Тэдгээр хүмүүс худалдаа хийхээр Египет рүү явж байлаа. Ах нар нь Иосефыг худалдаачдад 20 мөнгөн зоосоор зарчихав. *[Хүүхдүүдэд зоосыг үзүүлээд хамтдаа тоол.]*

Иосеф тэр нүхнээс гарсандаа баяртай байсан боловч ах нарыгаа өөрийг нь зарж байгааг мэдээд ихэд айжээ. Иосеф ах нараасаа гэртээ харихыг гуйсан боловч тэд огтхон ч сонссонгүй. *[Иосеф гунигтай ба айсан мэт харагдана.]*

Иосеф Египет явлаа. Тэр замдаа аавынхаа ярьж өгсөн Их Эзэний тухай олон түүхийг санаж Их Эзэнд бүрэн найдахаар шийдэв. Өөртэй нь хамт Их Эзэн байгаа гэдгийг тэр мэдэж байсан бөгөөд яагаад ийм зүйл өөрт нь тохиолдож байгааг ойлгосонгүй.

Бататгах нь

Хүүхдүүдэд хариулах боломж гаргаарай: **Ах нар нь түүнтэй уулзах дургүй байх нь Иосефт ямар байсан бэ? Ах нар нь түүнийг худалдаачинд боол болгон зарахад Иосефт ямар байсан гэж бодож байна вэ?**

Юу ч болж байсан Бурхан түүнд хайртай гэдгийг Иосеф мэдэж байсан бөгөөд Бурханд итгэж болно гэдгийг ч сайн мэдэж байжээ. Иосеф Бурханыг бүх зүрх сэтгэлээрээ хайрлаж Түүнд

итгэхээр шийджээ.

Та нар ямар нэгэн зүйлээс айдаг уу? Та нар өөрсдийн итгэлээ Бурханд өгч болно. Тэгвэл Тэр та нарыг хамгаалах болно. Өнөөдрийн хичээлийн гол санаа бол:



Бид айсан үедээ Их Эзэнд л найдах хэрэгтэй.

Намайг дагаад хэлээрэй.

Библи Судлал

Хэрэгтэй зүйлс:

Библи

Библиэ нээгээд Эхлэл 37:12-28-г гаргаарай. Ишлэл рүү заахдаа ингэж хэлээрэй: **Бидний**

өнөөдрийн үзсэн түүх Бурханы үг Библийн энэ хэсэгт бичигдсэн байдаг. Ишлэлүүдээс сонгож уншихдаа шаардлагатай бол өөрийн үгээр дэлгэрүүлж уншина уу.

Бататгах нь

Хүүхдүүдэд хариулах боломж гаргаарай: **Иосеф яагаад ах нараа эргэхээр явсан бэ? Ах нар нь хамгийн түрүүнд Иосефт юу хийсэн бэ? Ямар ах нь Иосефт тусалсан бэ? Бусад ах нар нь Иосефыг яахыг хүссэн бэ? Тэр хэр зэрэг мөнгөөр худалдагдсан бэ? Тэр ямар хол улс руу явж байсан бэ?**

Иосефыг айж байхад Их Эзэн түүнтэй хамт байсан уу? Иосеф

түүнийгээ санадаг уу? Иосеф юу хийхээр шийддэг вэ? (Бурханд итгэхээр) **Гол санаагаа хамтдаа хэлье:**



Бид айсан үедээ Их Эзэнд л найдах хэрэгтэй.

Цээжлэх Ишлэл

Библиэ нээгээд Дуулал 56:3-г гарган **"Өнөөдрийн бидний цээжлэх ишлэл Библийн маань энэ хэсэгт байна"** гээд ишлэлийг чангаар унш. **"Айх үедээ би танд итгэлээ өгнө"** гэсэн цээжлэх ишлэлээ заахдаа дараах хөдөлгөөнийг заагаарай.

Хэрэгтэй зүйлс:

Библи

Айх үедээ

Дээшээ хараад, айсан эсвэл гайхсан мэт харна.



би

Өөрийгөө заах.



Танд

Дээшээ заах.




итгэлээ өгнө.

Гараараа биеэ тэврээд бага зэрэг найгах.



Дуулал 56:3

Алгаа нийлүүлээд ном мэт дэлгэнэ.



3

Хичээлээ Заах

А. Итгэлийн Алхам

Хэрэгтэй зүйлс:
 нүд боох алчуур

Энэ үйл ажиллагаанд бэлдэхийн тулд, сандал болон бусад тавилгаар саад бартаатай зам хийгээрэй.

Хүүхдүүдийг хос болгоод нэгнийх нь нүдийг боож харин нөгөө нь нүдээ боосон найзыгаа хөтлөн явах болно. Хөтөлж буй хүүхэд нь найзыгаа дагуулан саад бартаатай замаар явна. Дараа нь хүүхдүүдийг сольж дахин давтаж үзээрэй.

Бататгах нь

Хүүхдүүдийн хариултыг сонсоорой: **Чи хаана явж байгаагаа харахгүй байхад ямар байсан бэ? Чи унах эсвэл ямар нэгэн зүйлд өөрийгөө цохих вий гэхээс айж байсан уу? Хэн нэгэн чамд тусалхад ямар байсан бэ? Хос болсон хүндээ итгэх нь амархан байсан уу? Хэцүү байсан уу?**

Чамайг нүдээ боосон байхад найз чинь их сонин газраар явсан. Тэдний зарим нь аймаар байсан байх. Чамайг өвтгөхөөс хамгаалах сайн зүйлийг найз чинь хийсэн байна уу?

Бодит амьдрал дээр, биднийг хөтөлж чадах хамгийн сайн нь хэн бэ? (Бурхан) Тэр бидний туслагч мөн найз байхыг хүсэж байна. Бид Түүнд юу мэдэрч байгаагаа хэлж болно. Биднийг айх үед Тэр бидэнд санаа тавьдаг бөгөөд үргэлж харж байдаг. Тэр өөрт нь биднийг итгэхийг хүсэж байна. Хичээлийн гол санаагаа санаж байна уу:



Бид айсан үедээ Их Эзэнд л найдах хэрэгтэй.

Намайг дагаад хэлээрэй.

Б. Айдсын Шидэлт

Хэрэгтэй зүйлс:
 бөмбөг

Хүүхдүүдийг шалан дээр тойрог хэлбэртэй суулга. Хэлэх: **Би та нар руу энэ бөмбөгийг**

шидэх болно. Үүнийг барих үедээ нэг айдаг зүйлээ хэл. Тэгээд өөр хэн нэгэн рүү бөмбөгөө шидээрэй. Тэгэхэд тэд өөр нэг зүйлийг хэлэх болно. (Жишээ нь: цахилгаан цохих, тэнгэр дуугарах, эмчид очих, том нохой, харанхуй, гал, дуу чимээ, төөрөх, хар дарж зүүдлэх, өндөр газар гэх мэт).

Бататгах нь

Хүүхдүүдийн хариултыг сонсоорой: **Өөр хүүхдийн хэлсэн зүйлүүд чиний ч гэсэн айдаг зүйлийн нэг байна уу? Юу нь энэ зүйлүүдийг аймаар болгож байна вэ? Чи айсан үедээ өөртөө тусалж чадах ямар нэг зүйлийг хийдэг үү?**

Та нарын хийж чадах нэг сайн зүйлийг би мэднээ. Есүст итгэж Түүнд залбир. Тэр чамд туслахыг хүсдэг. Тэр яг Иосефт санаа тавьсан шигээ чамд ч бас санаа тавьдаг бас хайртай гэдгийг нь мэдээсэй гэж хүсэж байна. Санацгаая:



Бид айсан үедээ Их Эзэнд л найдах хэрэгтэй.

Намайг дагаад хэлээрэй.

4

Хичээлээ Хуваалцах нь

Бурханы Гарт

Юуны өмнө, Бурханы гарны загвар зургийг (146-р хуудас) хүүхэд бүрт хувилж өгөөд хүүхдүүдээр гарыг будуулж дээр нь нэг айдаг зүйлийг нь бичүүл эсвэл зуруул (Том хүнээс тусламж авч болно).

Бататгах нь

Хүүхдүүдэд хариулах боломж гаргаарай. **Зурсан эсвэл бичсэн айдаг зүйл чинь юу вэ?**

Чамаас том бас чамайг айлгадаг зүйл чинь хүртэл Эзэн Бурханы гарт байдаг гэдгийг санаж яваарай. Чи айсан үедээ Түүнд итгэж болно. Чи айсан үедээ Түүнээс туслаач хэмээн залбирч болно. Тэр чамд хайртай бөгөөд залбирлыг чинь сонсож байдаг.

Энэ долоо хоногт, айх үедээ

үүнийг санаж бай. Зүгээр л нүдээ аниад айж байгаа айдсаа **Их Эзэний гарт өгч байна гээд төсөөлөөд үз. Их Эзэн чамайг хэзээ ч орхихгүй.**

"Түүний гарт бүх ертөнц бий" (Бяцхан хүүхдүүд Түүнийг магтана, № 125) дууг дуулахдаа "Түүний гарт миний айсан зүйл бий" гэж сольж дуулаарай.

Их Эзэний гараа гэртээ авч яваад хэн нэгэнтэй хуваалцаж түүнд Иосеф Их Эзэнд итгэсэн тухай ярьж өгөөрэй. Захиас үгээ сүүлийн удаа хамтдаа хэлцгээе:

Хэрэгтэй зүйлс:

- Бурханы гар загвар (х. 146)
- цаас
- өнгийн харандаа
- Бяцхан хүүхдүүд Түүнийг магтана дууны ном



Бид айсан үедээ Их Эзэнд л найдах хэрэгтэй.

Хичээлийн Хаалт

Хэлэх: **Есүс ээ, бидэнд санаа тавьж биднийг хайрладаг тань баярлалаа. Биднийг айсан үед хамт байна гэж амласанд тань талархaya. Танд итгэхэд бидэнд туслаач. Амен.**

Хэн Анхаарна гэж?

Унших Зүйл

Эхлэл 37:12-28;
Эцэг Өвгөд ба
Зөнчид, х. 208-
212.

Цээжлэх Ишлэл

"Айх үедээ би
танд итгэлээ
өгнө" (Дуулал
56:3).

Гол Санаа

**Бид айсан үедээ
Их Эзэнд л
найдах
хэрэгтэй.**

Чамд айдаг зүйл бий юу? Иосеф ихэд айсан бөгөөд тэр Их Эзэнд итгэхээр шийдсэн юм.

Нэгэн өдөр Иосефын том ах нар хонин сүргээ аваад гэрээсээ хол газар явжээ. Гэрийнх нь ойролцоо газрын бэлчээрийн өвс муудсан тул ах нар нь хонио туугаад өвс сайтай газар луу явсан байв. Олон хоног өнгөрсөн ч ах нар нь эргэж ирэхгүй л байлаа.

"Ах нартайгаа уулзаад ир дээ

миний хүү" гэж аав нь Иосефт хэллээ.

"Тэдэнд ямар нэгэн юм хэрэгтэй бол эргэж ирээд аавдаа хэлээрэй. Тэдний сайн байгаа эсэхийг мэдээд ирээрэй" гэв.

"За ааваа, би одоо тэдний хойноос явлаа" гэж Иосеф хэллээ. Урт замд зориулсан хоол хүнсээ базааж аваад нөгөө сайхан урт дээлээ өмсөөд замдаа гарлаа. Тэр

явсаар л байлаа, явсаар л байлаа. Ах нарынхаа байгаа газарт очтол олон өдөр явлаа.

Нэгэн өглөө ах нар нь холоос Иосеф дүү нь тэднийг чиглэн ирж явааг харжээ. "Хөө өнөө зүүдлэгч ирж явна" гэж нэг ах нь тохуурхан хэллээ.

"Тэр энд юу хийж яваа юм бол" гэж нөгөө нь асуув. Тэгээд тэд Иосефыг яахаа ярилцаж аймшигтай муухай төлөвлөгөө зохиов.

"Өө, та нар энд байсан юм уу" гэсээр Иосеф ах нар луугаа гүйсээр ирлээ. Түүний нүүр дүүрэн инээмсэглэл ах нарынхаа гэнэт зууран барих барилттай хамт замхрав. Эхлээд ах нар нь олон өнгөтэй гоё

дээлийг нь угз татан тайлжээ. Тэгээд тэд мацаад мацаад гарч чадахааргүй гүнзгий нүх рүү дүүгээ шидэж орхив.

Ингээд ах нар нь түүдэг галынхаа дэргэд суугаад хоолоо идэцгээжээ. Харин Иосефын том ах Реубен бусдынхаа хийсэн зүйлд сэтгэл дундуур байлаа. Тэрээр хэсэг

хугацааны дараа дүүгээ нүхнээс нь татаж гаргаад гэртээ буцаана даа гэж дотроо нууцаар төлөвлөж байв.

Реубен хонио хариулж явахдаа энэ талаар бодож амжив.

Реубеныг хонио зайдуухан хариулж байхад нь нөгөө нэг ах Иуда нь холын бараа харж зогсов. "Худалдаачид ирж явна" хэмээн тэр хашгирлаа. Энэ муу

зүүдчинээс салах нэг арга оллоо. Иосефыг тэдэнд зарчихъя. Иосеф боол болох болно. Ах нар нь ийм л зүйлийг хийсэн билээ.

Ингээд тэд Иосефыг 20 мөнгөн зоосоор худалдаачдад зарсан юм.

Эхлээд Иосеф айн, чичрэн уйлж байлаа. Дараа нь аавынхаа ярьж өгдөг байсан Бурхан өөрийг нь хэрхэн харж хамгаалдаг байсан тухай олон түүхийг санаж эхэллээ. Иосеф өөрийг нь Эзэн Бурхан харж анхаарал тавьж байгаа гэдэгт итгэхээр шийдлээ. Өөрт нь яагаад ийм муу муухай зүйл тохиолдоод байгааг тэрээр ойлгохгүй байсан ч түүнийг хаана ч очсон Бурхан дандаа хамт байх болно гэдэгт итгэж байсан юм.



Дасгал Ажил



Шаббат

Энэ долоо хоногийн өдөр бүр хичээл дээр үзсэн түүхийг хамтдаа уншаад цээжлэх ишлэлээ давтахдаа дараах хөдөлгөөнийг хийгээрэй.

- Айх үедээ**Дээшээ хараад, айсан эсвэл гайхсан мэт харна.
- би**Өөрийгөө заах.
- Танд**Дээшээ заах.
- итгэлээ өгнө.**Гараараа биеэ тэврээд бага зэрэг найгах.
- Дуулал 56:3**Алгаа нийлүүлээд дэлгэнэ.

Ням

Эхлэл 37:12-28-г хамтдаа уншаад асуух нь: Иосефын ах нар яагаад түүнд атаархсан бэ? Иосеф яагаад ах нар дээрээ очсон бэ? Иосефын ах нар ямар 2 зүйл хийсэн бэ? Иосеф яасан бэ?

Иосеф хэдэн ахтай байсныг хүүхдээрээ тоолуулаад дараа нь гэрт чинь хэдэн хүүхэд байдгийг тоолуулаарай.

Даваа

Шаббат хичээл дээр хийсэн Их Эзний гараа энэ долоо хоногт хэн нэгэнтэй хуваалцаж түүнд Иосефын тухай ярьж өгөхөд нь хүүхдээ урамшуулаарай. Их Эзэн тэднээс том, айсан зүйл нь Түүний гарт байдаг гэдгийг хүүхдэдээ сануул.

Мягмар

Хүүхдийнхээ нүдийг боож итгэлийн алхам хийгээрэй. Тэднийг хөтлөн яв. Дараа нь хүүхэд

тань таныг дагуулан итгэлийн алхам хийнэ. Юу мэдэрсэн тэмдэглэлээ харьцуул. Зөв чигт чиглүүлэхэд нь Их Эзэнд итгэж болохыг хүүхдэдээ сануул.

Дараагийн удаа хүүхэд тань ямар нэгэн юмнаас айвал, хамтдаа залбираад цээжлэх ишлэлийнхээ тухай ярилц.

Лхагва

Элсээр тоглож байхдаа

Египет улс ямар их элстэй болохыг хэл.

Иосеф Египет рүү явсан замыг элсэн дээр гарга.



Пүрэв

Хүүхдээ өндөр сандал эсвэл ширээн дээр зогсоогоод үсрэхэд нь гараараа тосон ав. Итгэлийн тухай ярилцаад асуух нь: Чамд туслахын төлөө чи Их Эзэнд үргэлж итгэж чадах уу?

Чиний итгэдэггүй хэн нэгэн хүн бий юу? Танихгүй хүнтэй харьцах хувийн зан чанарын тухай ярилц.

Баасан

Гэр бүлтэйгээ хамтран Библийн түүхийг жүжигчилэхэд Иосеф болсон нь нөмрөг эсвэл цамц өмсөж болно.

Айдсын тухай ярилц. Хүүхдүүд айж болох үе бий юу? Хэзээ? Яагаад? Их Эзэнд итгэх тухай дуу дуул. Бидэнтэй үргэлж хамт байдаг нь Их Эзэнд талархаарай.

